

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2025 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	3.6. Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	3.6.1. Газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоосон байна.	2021 - 2025			Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 181 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хууль, тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн хавсралтын 3,5,6,7,10 дугаар заалтуудад тусгагдсан Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагын хүрээнд боловсруулж, батлуулахаар хуулийн төслүүдийн үзэл баримтлал, хуулийн төслийг эцэслэн боловсруулах, батлуулах үүрэгтэй ажлын хэсгүүд байгуулагдан, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй хамтран ажиллаж байна. Үүнд: ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны А/148 Тушаалаар Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулахаар 12 яам, 13 агентлаг, их, дээд сургууль, төрийн бус байгууллагууд, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, геодези, зураг зүйн инженерүүдэд албан бичгээр урилга хүргүүлж, 2025 оны 06 дугаар сарын 02, 05-ны өдрүүдэд хуулийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан https://www.gazar.gov.mn/post/geodezi-zurag-z-jn-tuhaj-huulijn-shinechilsen-najruulgyn-t-slijn-helelc-leg-zohion-bajguullaa . Хуулийн төслийг байгууллагын веб хуудаст 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр байршуулж https://www.gazar.gov.mn/post/geodezi-zurag-z-jn-tuhaj-huulijn-shinechilsen-najruulga олон нийтийн санал авсан.	70

					Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт албан бичиг хүргүүлж санал авсан. Ажлын хэсгийн аналыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаж, товёг үйлдсэн. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хуулийн төслийг хэлэлцүүлсэн. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг баталж өгөх хүсэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1/190, 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 1/2189 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т тус тус хүргүүлсэн, үзэл баримтлалыг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр, 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр тус тус баталсан. ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны А/145 тушаалаар Газрын тухай хуулийн төслийн үзэл баримтлалтын төсөл, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Уг ажлын хэсгийн хүрээнд Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан, хуулиудийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан зэргийг их, дээд сургуулийн эрдэмтэн судлаачдаас бүрдсэн зөвлөх багаар гүйцэтгүүлэн 2025 оны 10 сард ажлын хэсэг болон Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээж авсан. Эдгээр судалгааны тайлангуудад үндэслэн Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудын төсөл, тэдгээрийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж, 2025 оны 11 дүгээр сард тус газрын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал авч, ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны А/229 дүгээр тушаалаар Кадастрын тухай хуулийн төслийн үзэл баримтлалтын төсөл, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ, хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлыг тооцоог шинэчлэн боловсруулахаар Монголын Кадастрын холбоотой 2025 оны 2025/117 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажилласан.	
--	--	--	--	--	--	--

					Ажлын хэсэг нь зөвлөхөөс өгсөн зөвлөмжийн дагуу хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, мөн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан ГЗБГЗЗЕГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гаргасан шийдвэрийн дагуу хуулийн төсөлд олон нийтээс санал авах ажлыг https://old.gazar.gov.mn/legacy/get-feedback-on-draft-law/8956438 цахим хуудсанд байршуулж зохион байгуулан ажиллаж байна. Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулагдан, Хаягжуулалтын тухай хуулийн төслийг боловсруулан ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох ажлыг зохих журмын дагуу зохион байгуулан боловсруулж, баримт бичгийн бүрдлийг хангуулсан. Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох материалын хамт Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр холбогдох сайд нараар батлуулсан. Харин Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Хаягжуулалтын тухай хуулийн үзэл баримтлалын төслийг дахин батлуулахаар 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 1/2475 дугаар албан бичгээр Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайд нараар баталгаажуулсан бөгөөд одоо Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулахаар тус яаманд хүргүүлээд байна. Энэхүү үзэл баримтлалын дагуу Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 6 бүлэг, 17 зүйл, 55 хэсэг, 120 заалттайгаар боловсруулсан.	
--	--	--	--	--	--	--

					Хаягжуулалтын тухай хуулийн төслийг байгууллагын веб хуудаст 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр (https://old.gazar.gov.mn/legacy/tsanal/hayagzhuulaltyn-tuhaj-huulijn-shinechilsen-najruulgyn-t-s-ld-sanal-avch-bajna) болон 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр (https://old.gazar.gov.mn/legacy/get-feedback-on-draft-law/6597348) байршуулж олон нийтийн санал авсан. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн үзэл баримтлалын төслийг 5 бүлэг, 21 зүйлтэйгээр боловсруулан 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 1/3145 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох тооцоо, судалгааны хамт хүргүүлсэн. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/368 дугаар тушаалаар Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, 2025 оны 12 дугаар сарын байдлаар 2 удаа хуралдаж гишүүдээс өгсөн саналын дагуу хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтийг тусгасан.	
2		3.6.2. Хаягжилтын нэгдсэн системийг Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулна.	2021 - 2025		2020-2022 онд “Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн систем байгуулах” ажлын хүрээнд хаягийн өгөгдөл мэдээллийг засварлаж, 21 аймгийн 330 сумын хэмжээнд хаягийн мэдээллийн системийг хаягжуулах үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Засгийн газрын 2022 оны 180 дугаар “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” тогтоолын дагуу 21 аймгийн 330 сумын хэмжээнд Хаягийн мэдээллийн системийг нэвтрүүлэн шинэчилсэн хаяг олгосон. Хаягийн мэдээллийн системд 21 аймгийн 330 сумын хэмжээнд 50530 гудамж, зам, 689,888 барилга, 1139127 нэгж талбар, 258,650 газар, усны нэр, 628,436 орц, гарцын мэдээллийг оруулж тус тус хаяг олгоод байна. 2023 оноос нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд гудамж, зам, талбай, орц, гарцыг зураглаж хаягийн орон зайн өгөгдөл мэдээллийг бүрдүүлсэн. Нийслэлийн хэмжээнд 41598 гудамж, зам, 318510 барилга, 516963 нэгж талбарт тус тус хаяг олгоод байна. 2024 онд “Хаягийн мэдээллийн системийн нэмэлт хөгжүүлэлт” хийх ажлын хүрээнд хаягийн мэдээллийн системийг боловсронгуй болгож, хаяг олгох үйл ажиллагааг	90

					бүрэн автоматжуулах, цахимжуулах, нээлттэй веб-д суурилж хөгжүүлсэн. 2025 онд “Хаягийн мэдээллийн систем”-д нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн шинэ системийг нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумдад хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Үүнд:Олон улсын жишигт нийцсэн хаягийн удирдлагын системийн сургалтыг нийслэл, 9 дүүргийн Газар зохион байгуулалтын албаны холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж, Чингэлтэй дүүргийн хэмжээнд, 2025 оны 08 дугаар сарын 22-ний өдөр Хүннү хотын Захирагчийн ажлын алба, Сүхбаатар дүүргийн газар зохион байгуулалтын мэргэжилтэнүүдэд, 2025 оны 09 сарын 09 ны өдөр Баянгол, Хан-Уул дүүргийн ГЗБА-ны мэргэжилтэнүүдэд сургалтыг тус тус зохион байгуулж, хаягийн мэдээллийн системийг хэрэглээнд нэвтрүүлээд байна. Монгол улсын Засгийн газар болон БНСУ-ын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яам мөн Газар геоматик корпорацтай хаягийн талаар харилцан мэдээлэл солилцох хамтран ажиллах санамж бичгүүдийг байгуулсан. БНСУ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын санхүүгийн дэмжлэгт тулгуурлан “Монгол Улсын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх” төслийг 2026-2029 оны хооронд 8 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдэн, хамтран ажиллаж байна.	
3		3.6.3. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ.	2021 - 2025		Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа: Газрын мониторингийн сүлжээний цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг 2021 онд 1000 мониторингийн цэгт, 2022 онд 400 мониторингийн цэгт, 2023 онд 350 мониторингийн цэгт, 2024 онд 300 мониторингийн цэгт, 2025 онд 500 мониторингийн цэгт буюу нийт 2550 мониторингийн цэгт улсын төсвийн хөрөнгөөр зохион байгуулж, хөрсний элэгдэл, эвдрэл, доройтлын байдлыг тодорхойлж, иргэн, хуулийн этгээдэд олгосон газар болон бусад газруудын ашиглалт, төлөв байдалд төрөөс тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд Булган, Дорноговь, Өвөрхангай, Дорнод аймгийн 4 сумын нутаг дэвсгэрт бэлчээрийн газрын төлөв байдлын, чанарын хянан баталгааны ажлыг хийсэн бөгөөд энэ ажлын хүрээнд 53	100

					мониторингийн цэгт буюу 636,976.5 га талбайд, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хэнтий зэрэг 9 аймгийн 39 сумын нутаг дэвсгэрт хот, тосгон, бусад суурины газрын төлөв байдлын, чанарын хянан баталгааны ажлыг гүйцэтгэж, энэ ажлын хүрээнд 440 мониторингийн цэгт буюу 114,506 га талбайд, нийслэлийн Баянгол, Багахангай, Багануур, Сонгинохайрхан, Хан-Уул, Налайх 6 дүүргийн нутаг дэвсгэрт хот, тосгон, бусад суурины газрын мониторингийн 481 цэгт буюу 316,262 га талбайд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2025 онд сум, дүүрэг, нийслэлийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг нэгтгэвэл нийт 936 мониторингийн цэгт буюу 1,067,744 га талбайд 2,011,841,150 төгрөгийн санхүүжилтээр газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэснээр газрын мониторингийн нэгдсэн мэдээллийн санг газрын мониторингийн өгөгдөл, мэдээллээр шинэчлэн бүрдүүлээд байна. Иргэд, хуулийн этгээд өөрсдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй 84.400 нэгж талбар бүхий газартаа хийлгэсэн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлтийг 2021-2025 оны хооронд газрын мониторингийн цахим системээр баталгаажуулсан. Газрын мониторингийн цахим систем: Газрын мониторингийн цахим системийг 2023-2024 онд шинэчлэн хөгжүүлж, газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа, газарт учруулсан хохирол, нөхөн сэргээлт, бэлчээрийн төлөв байдлын статистик дашбоардын нэмэлт хөгжүүлэлт хийж, хиймэл дагуулын /Mongolian data cube/-г мониторингийн орон зайн дүн шинжилгээнд холбож, egaza.gov.mn цахим хуудсаар дамжуулан хэрэглэгчдэд хүргэж байна. Мөн бэлчээрийн фото мониторингийн хээрийн судалгааг хийх “Belcheer” гар утасны аппликейшнийг хөгжүүлж, хэрэглээнд гаргасан. Газрын мониторингийн цахим системд итгэмжлэгдсэн лабораториудыг холбож, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын хөрс, усны шинжилгээний мэдээллийг оруулах ажлыг цахимжуулсан. Мониторингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын мэдээллийг харах дундын мэдээллийн сан хөгжүүлэн, хэрэглээнд нэвтрүүлсэн. Газрын мониторингийн цахим системд зайнаас тандан судлал, өндөр нарийвчлал	
--	--	--	--	--	---	--

					бүхий хиймэл дагуулын зураг ашиглан мониторинг хийх, бохирдол, доройтолд орсон байршлуудыг тодорхойлж, 2025 онд нөхөн сэргээлт хийх үйл ажиллагааг цахимжуулж, хяналт тавих шинэ цэсийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Газрын мониторингийн эрх зүйн орчинг сайжруулах: Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-ыг шинэчлэн батлуулсан. Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар “Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн мониторинг хийх аргачилсан заавар”-ыг 2022 онд, “Зайнаас тандан судлалын аргаар тариалангийн мониторинг хийх аргачилсан заавар”-ыг 2025 онд ГЗБГЗЗЕГ-ын даргын А/186 дугаар тушаалаар “Газрын мониторингийн цэгийг шинээр байгуулах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох аргачлал”, А/241 дүгээр тушаалаар “Бэлчээрийн фото мониторингийн цэгийн төлөөлөх талбайг зураглах аргачилсан заавар”, А/386 дугаар тушаалаар “Газрын доройтлыг тодорхойлох аргалал”, А/399 дүгээр тушаалаар “Газрын төлөв байдал, чанарыг сайжруулах, доройтол, бохирдлыг бууруулах аргачлал”-ыг тус тус боловсруулан батлуулсан.	
4		3.6.4. Монгол Улсын геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зургаар бүрэн хангана.	2021 - 2025		Монгол Улсын геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулах: 2021 онд Өндрийн I ангийн сүлжээг 2 полигон, 472 цэгтэйгээр байгуулж, 2022-2023 онд Геодезийн сүлжээний эхлэл цэгийг өндрийн I ангийн сүлжээтэй холбосон. “Монгол орны өндрийн тулгуур сүлжээг шинэчлэх” ТЭЗҮ-ийг боловсруулан 2023 онд батлуулсан, өндрийн II ангийн сүлжээний 6 шугамаар ОХУ-ын өндрийн сүлжээтэй холбохоор ажиллаж байна. “Геодезийн сүлжээний эхлэл цэгийг өндрийн I ангийн сүлжээтэй холбох, хэмжилт хийх” ажлыг зохион байгуулсан. 2024 онд Өндрийн I ангийн сүлжээний цэгийн солбицол, өндрийн утгын жагсаалтыг Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн. 2023 онд “Монгол Улсын GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээг өтгөрүүлэх, байнгын ажиллагааг хангах” техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоог шинэчлэн боловсруулж баталсан. 2024 онд Монгол Улсын геодезийн байрлалын сүлжээг өтгөрүүлэх, нарийвчлалыг сайжруулах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр 5-н аймгийн 5-н суманд шинээр байнгын	80

					ажиллагаатай 5 суурин станц байгуулснаар улсын байрлалын сүлжээний 48 станцтай болсон. 2024 онд Монгол улсын Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд улсын байрлалын сүлжээний дээд ангийн идэвхитэй цэг тэмдэгт болох GNSS-ийн байнгын ажиллагаатай 48 суурин станцуудын солбицлыг ITRF2020 солбицлын тогтолцоонд тодорхойлж, хурдны вектор утгыг бодож батлан хэрэглээнд нэвтрүүлээд байна. Нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зургаар бүрэн хангах: 2024 онд Нийслэл болон 2 аймгийн 5 сумын төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр ажлын даалгаврыг боловсруулж, батлуулсан. “Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах”, “Монгол орны өндрийн тулгуур сүлжээг шинэчлэх” ТЭЗҮ-ийг Барилга, хот байгуулалтын Дэд сайдаар батлуулсан. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын саналыг 2020-2023 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төсвийн төсөлд тусгуулахаар БХБС-ын албан тоотыг Сангийн яаманд хүргүүлсэн хөрөнгө тусгагдаагүй. 2024 онд Боомтын сэргэлтийн хүрээнд хийгдэх 1:25000-ны масштабтай байр зүйн зураглалын ажлын төсвийн тооцоог гаргаж, 2025 оны төсөвт тусгуулахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн хөрөнгө тусгагдаагүй. МУҮАБ-д Монгол Улсын нутаг дэвсгэрийн баруун бүсийг 1:25000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын танилцуулга болон төсвийн тооцоог хүргүүлсэн. 1:25000-ны масштабтай байр зүйн зургийг хийх ажлын үндэслэл, хэрэгцээ, шаардлага, төсвийн тооцоо гаргаж 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн н/21 дугаартай албан бичгээр МУҮАБЗ-д хүргүүлсэн. 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 1/2234 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэв. - 2025 онд Монгол Улсын хамгийн өндөр цэг хэмжих ажлыг зохион байгуулж /Таван Богд уул /3 улсын уулзварын цэг/, Хүйтэн уул өндрийг хэмжиж тогтоосон тайланг шалгаж, 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн ГЗЗХ/2025/23 дугаартай	
--	--	--	--	--	--	--

					дүгнэлтээр "Мөнххайрхан уулын Барилгачин оргил, Хар Ан уулын солбицол, өндрийг тодорхойлох" ажлын тайланг шалгаж, 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн ГЗЗХ/2025/28 дугаартай дүгнэлтээр Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн санд хүлээн авсан. - 2025 онд Дэлхийн геодезийн хангамжийн сүлжээг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын геодезийн сүлжээ (байрлал, өндөр, гравиметр)-г сайжруулах, хэрэглээг нэмэгдүүлэх, тулгамдаж буй асуудлыг тогтоох, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, 2025-2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, төсвийг тооцоолон гаргах, санхүүжүүлэх эх үүсвэрийг судлах үүрэг бүхий геодезийн сүлжээний Ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулан, Газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/287 дугаартай тушаалаар 23 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. - 2025 оны А/287 дугаартай тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулав. Хурлаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дэлхийн Геодезийн Шилдгүүдийн Төв (UN-GGCE) болон А хавсралтад жагсаасан гишүүн улсын засгийн газрын байгууллага, агентлагууд, хувийн хэвшлийн компаниуд, байгууллагууд, холбоод, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн талаарх мэдээлэл танилцуулгыг хийж, Монгол Улсын геодезийн сүлжээг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2028 он)-г хэлэлцүүлэн хамтран ажилласан. - Ази-Номхон далайн бүсийн геодезийн сүлжээний 5 станцын /UB01, HUV1, OMA1, OVA1, DOA1/ 2025 оны 09 дүгээр сарын 08-14-ны хоорон дахь GPS-ийн долоо хоногийн өдрүүдийн 24 цагийн статик өгөгдлийг Rinex 2.11 хувилбараар, станц тус бүрийн хүлээн авагч, антены мэдээллийг агуулсан баримт бичгийн хамт Ази номхон далайн бүс нутгийн геодезийн сүлжээний GPS-ийн комданит ажлын хэсэгт ftp2.ga.gov.au серверт 2025 оны 09 дүгээр сарын 30-ний өдөр байршуулсан. 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/242 дугаар "ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тушаал батлагдсан. Тус тушаалын хавсралтанд заасан "Геодезийн сүлжээ, байнгын цэг, тэмдэгтийн мэдээллийн дэд систем	
--	--	--	--	--	---	--

					хөгжүүлэх” ажлын даалгаварыг 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн АД/2025-55 дугаар тушаалаар батлуулсан. Гэрээт ажлын эцсийн тайланг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн ГЗЗХ/2025/38 дугаар дүгнэлтээр Геодези, зураг зүйн нэгдсэн санд хүлээн авсан. 2025 онд Улсын хэмжээнд 4 сум, 6 дүүргийн хэмжээнд 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 тогтолцоонд хийх ажил хийгдсэн. Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурван тэс сумдын гүйцэтгэлийн ӨМАХААГ/20240101635 дугаартай ажлын тайланг шалгаж, 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн ГЗЗХ/2025/36 дугаар актаар хүлээн авсан. Улаанбаатар хотын 6 дүүргийн 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн эцсийн шатны тайланд 2025/145 дугаар гэрээний дагуу захиалагчийн хяналт хийж байна. 2026 онд Орхон аймгийн Баян-Өндөр сумын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг хийх 2025/70 дугаар ажлын даалгавар батлагдаж, төсөв батлуулахаар ажиллаж байна. 21 аймгийн засаг дарга нарт 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 1/3582 дугаар албан бичгээр 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх төсвийг орон нутгийн төсөвт тусган ажиллах санал хүргүүлсэн.	
5		3.6.5. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ.	2021 - 2025		Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэлийг хөгжүүлэх талаар: “Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газрын сан бүрдүүлэх, газар хөгжүүлэлт хийх” ажлын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, 2023 онд Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх ШУТТЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдэн техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан. 2024 онд Газрын биржийн цахим системд газрын нөөц сан байгуулж, бүртгэх боломжийг бүрдүүлэх, газар хөгжүүлэлттэй холбоотой Кадастрын бүртгэлийг орон зайд суурилсан үндсэн агуулгаар нь хөгжүүлж 2D /хэмжээст/ кадастрын системийг байгуулсан. Тус системд Монгол улсын хэмжээнд 1,710,964 өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүсэн нэгж талбар бүхий газар бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээр газартай холбоотой 2D хэмжээст улсын бүртгэлийн харилцааг эрхлэн явуулж байна.	90

					Кадастрын мэдээллийн нэгдсэн системийг өргөжүүлэн, газар болон түүн дээр байрлах аливаа үл хөдлөх эд хөрөнгийн бодит зураглал, бүртгэл, мэдээлэл 3D /хэмжээст/ байдлаар бүрдүүлэх, үл хөдлөх эд хөрөнгийн цогц мэдээлэл бүхий нэгдсэн гурван хэмжээст бүртгэл бий болгох зорилгоор хот байгуулалтын кадастрын систем, хаягийн мэдээллийн системтэй холбож дундын мэдээллийн сан байгуулсан. Одоогийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газар гэсэн 2 байгууллагуудтай харилцан мэдээллээ тухай бүр солилцож, нийт 500,000 барилгын бүртгэлийг нэгтгэж, 2D хэмжээст Газар болон үл хөдлөх, эд хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн санг үүсгээд байна. Мөн кадастрын объектыг гурван хэмжээст нэгж талбар бүрээр дүрслэн илэрхийлж түүнтэй холбогдох субъект болон эрх, эрхийн хязгаарлалт, эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг хариуцлагын мэдээллийг орон зай, цаг хугацааны агуулгатайгаар бүртгэх, түүнчлэн зах зээлийн үнэ, жишиг үнэ, татвар төлбөрийн мэдээллийг хамруулах зорилгоор гурав болон дөрвөн /3d, 4d/ хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах ТЭЗҮ-г улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн 2022 оны 11 дүгээр сард батлуулаад байна. Газрын үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/30 дугаар тушаалаар Газрын биржийн цахим системийг, мөн 2020 оны А/05 дугаар тушаалаар Газрын төлбөр, татварын цахим систем, Газрын үнэлгээний цахим системийг тус тус хэрэглээнд нэвтрүүлсэн. Мөн 2021-2025 ондуудад Газрын төлбөр, татварын цахим систем, Газрын үнэлгээний цахим систем, Газрын биржийн цахим системд жил бүр тогтмол нэмэлт, хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд тус системүүдийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус газрын даргын 2025 оны А/03 дугаартай тушаалаар Газрын биржийн цахим системийн (www.mle.mn)-ийн	
--	--	--	--	--	---	--

					шинэчилсэн 3.0 хувилбарыг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн. Мөн 2021-2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 19125 газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдаа зохион байгуулж, 26,941 иргэн, хуулийн этгээд оролцсон. Газрын биржийн цахим системээр зохион байгуулсан дуудлага худалдаанаас жилд дундажаар 23.4 тэрбум, 2020-2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл нийт 125.6 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.	
--	--	--	--	--	--	--